



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/31

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын Соёлын төвөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу “Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Есөн цагаан цацал” хүндэтгэлийн тоглолтонд оролцож буй эмэгтэйчүүдэд гарын бэлэг гардуулж, шагнал гардуулах үйл ажиллагаанд 500,000 (таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Уг арга хэмжээнд зарцуулагдах 500,000 (таван зуун мянга) төгрөгийг хууль журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж, Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу зарцуулахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох ажлыг зохион байгуулж, ажлын тайланг гаргаж ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ